

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 04 ДҮГЭЭР САРЫН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**


2025 оны 05 дугаар сарын 09

Улаанбаатар хот

Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх, үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэх, үйлчилгээг сайжруулах, удирдлагыг мэдээллээр хангах зорилгоор байгууллагын үйл ажиллагааны 04 дүгээр сарын биелэлтэд Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх журам”-д заасны дагуу төлөвлөгөөнд тусгагдсан 3 зорилтын 33 арга хэмжээг хамруулан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Шинэчлэгдэн батлагдсан журмын хүрээнд хяналт-шинжилгээ хийхэд нийт арга хэмжээний 87.9 хувь нь бүрэн хангалттай буюу 100-85 хувь, 9.1 хувь нь хангалттай буюу 85-70 хувь, 3 хувь нь хангалтгүй буюу 70 хүртэл хувьтай үнэлэгдлээ. (График 1, Хүснэгт 1)

График 1



Хүснэгт 1

Нийт арга хэмжээ	Арга хэмжээний зорилт, хэрэгжилтийн үнэлгээ (хувиар)			Хувь
	Бүрэн хангалттай	Хангалттай	Хангалтгүй	Дундаж хувь
	100 хүртэл	85 хүртэл -70-с дээш	70 хүртэл	
1	2	3	4	8
33	29	3	1	95.1

Зорилт тус бүрээр ангилан авч үзвэл Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд “Гадаадын иргэнд холбогдох асуудлаар зөвшөөрөл, бүртгэл, мэдээлэл, хяналтыг эрхлэн зохион байгуулна” зорилтод тусгагдсан арга хэмжээнүүд бүрэн хангалттай буюу 98.5 хувийн биелэлттэй, Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд “Олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, санхүүгийн чадавхыг бэхжүүлнэ” зорилтод тусгагдсан 25 арга хэмжээнүүдийн дундаж үнэлгээ нь мөн адил бүрэн хангалттай буюу 95.2 хувийн биелэлттэй бол Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтын хүрээнд “Технологийн дэвшилд тулгуурлан гадаадын иргэний бүртгэл, хяналтыг сайжруулна” зорилтын хүрээнд төлөвлөгдсөн арга хэмжээ нь хангалтгүй буюу 70 хувиар тус тус үнэлэгдсэн. (График 2, Хүснэгт 2)

Хүснэгт 2

Д/д	Нэгжийн нэр	Нийт арга хэмжээ	100%	90%	70%	50%	30%	Дундаж хувь
1	2	3	4	5	6	7	8	9
1	Технологийн дэвшилд тулгуурлан гадаадын иргэний бүртгэл, хяналтыг сайжруулна	1	-	-	1	-	-	70
2	Гадаадын иргэнд холбогдох асуудлаар зөвшөөрөл, бүртгэл, мэдээлэл, хяналтыг эрхлэн зохион байгуулна	7	6	1	-	-	-	98.5
3	Олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, санхүүгийн чадавхыг бэхжүүлнэ	25	21	1	2	1	-	95.2
Нийт		33	27	2	3	1	-	87.9

График 2



Чиглэл тус бүрээр авч үзвэл Захиргаа, удирдлагын газар, Виз, зөвшөөрлийн газар, Санхүү, хангалт үйлчилгээний газар, Мэдээллийн технологийн хэлтэс төлөвлөсөн арга хэмжээнүүдийн үнэлгээ буурч үр дүнг нэмэгдүүлж, эрчимжүүлэх шаардлагатай бол бусад нэгжийн төлөвлөн хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд бүрэн хэрэгжиж 100 хувиар үнэлэгдсэн. Үнэлгээ буурсан арга хэмжээнд:

- Захиргаа, удирдлагын газар: удирдлага, зохион байгуулалт хангалтгүй-1, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй боловч үр дүн гарч эхэлсэн-1, нийт 2 арга хэмжээ;

-Виз, зөвшөөрлийн газар: зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй-1, нийт 1 арга хэмжээ;

-Санхүү, хангалт үйлчилгээний газар: шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй-2, нийт 2 арга хэмжээ;

-Мэдээллийн технологийн хэлтэс: шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах-1, нийт 1 арга хэмжээ;

Хүснэгт 3

Д/д	Нэгжийн нэр	Нийт арга хэмжээ	100%	90%	70%	50%	30%	Дундаж хувь
1	2	3	4	5	6	7	8	9
1	Захиргаа, удирдлагын газар	15	13	1	-	1	-	96
2	Виз, зөвшөөрлийн газар	2	1	1	-	-	-	95
3	Иргэний харьяаллын газар	1	1	-	-	-	-	100
4	Зөрчил шалган шийдвэрлэх газар	3	3	-	-	-	-	100
5	Санхүү, хангалт, үйлчилгээний газар	3	1	-	2	-	-	80
6	Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс	3	3	-	-	-	-	100
7	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс	2	2	-	-	-	-	100
8	Мэдээллийн технологийн хэлтэс	1	-	-	1	-	-	70
9	Зөвлөгөө, мэдээллийн хэлтэс	1	1	-	-	-	-	100
10	Захиргаа, удирдлагын газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс хамтарсан	1	1	-	-	-	-	100
11	Санхүү, хангалт, үйлчилгээний газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс хамтарсан	1	1	-	-	-	-	100
Нийт		33	27	2	3	1	-	94.6

График 3



Мөн газар хэлтсүүдийн буюу Захиргаа, удирдлагын газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс хамтарсан 1 арга хэмжээ, Санхүү, хангалт, үйлчилгээний газар, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэс хамтарсан 1 арга хэмжээний биелэлт 100 хувь үнэлэгдсэн байна. Үүнд:

Дүгнэлт, зөвлөмж

Байгууллагын 2025 оны 04 дүгээр сард төлөвлөн гүйцэтгэсэн 33 арга хэмжээний хэрэгжилт 95.1 хувьтай үнэлэгдлээ. Энэ нь өмнөх сарын үйл ажиллагааны үнэлгээнээс 9 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд үнэлгээ буурсан арга хэмжээнүүдийн үр дүнг сайжруулж, цаашид дараах арга хэмжээг авч ажиллах шаардлагатай. Үүнд:

1. “Бүрэн хангалттай” буюу 85 буюу түүнээс дээш хувьтай үнэлэгдсэн

Гадаадын иргэнд олгох Монгол Улсын виз, зөвшөөрлийн үйлчилгээг зохион байгуулах (хэрэгжилт 90 хувь)

-Виз, зөвшөөрлийн газар нь үр дүнг нэмэгдүүлж, арга хэмжээг бүрэн гүйцэтгэх;

Иргэн, аж ахуй нэгж, байгууллага, албан хаагчаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч, шуурхай шийдвэрлэх (хэрэгжилт 90 хувь)

- Захиргаа, удирдлагын газар нь тухайн арга хэмжээний үр дүнг нэмэгдүүлэх;

2. “Хангалттай” буюу 70-85 хүртэл хувьтай үнэлэгдсэн

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланг Сангийн яамны Finperform санхүүгийн нэгдсэн шинэ системд тайлагнах (хэрэгжилт 70 хувь)

Улсын тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хураамжийн орлого төвлөрүүлэлтэд хяналт тавих (хэрэгжилт 70 хувь)

-Санхүү, хангалт, үйлчилгээний газар нь дээрх хоёр арга хэмжээний үр дүнг нэмэгдүүлж, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулан 2024 оны тооцоог нийлж, баталгаажуулж дуусгах;

“Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” (ISF) системийг сайжруулах (хэрэгжилт 70 хувь)

- Мэдээллийн технологийн хэлтэс нь шалгуур үзүүлэлтэд тусгагдсан үйлчилгээний хөгжүүлэлтүүдийг бүрэн хийж дуусгах, зохион байгуулалт, хариуцлагыг нэмэгдүүлэх;

2. “Хангалтгүй” буюу 70 хүртэл хувьтай үнэлэгдсэн

Байгууллагын даргын 2024 оны А/357 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсгийн үйл ажиллагааг эрчимжүүлж, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай

хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний төсөл боловсруулах (хэрэгжилт 50 хувь)

-Захиргаа, удирдлагын газар нь зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтийн дагуу бүрэн хэрэгжүүлж, зохион байгуулалтыг сайжруулах;

Мөн бусад газар, нэгжүүд төлөвлөгөөний шалгуур үзүүлэлт, зорилтот түшиндээ нийцүүлэн, товч тодорхой, үнэн зөв тайлагнаж, хугацаанд нь хэрэгжүүлж, үр дүнг нэмэгдүүлж ажиллахыг зөвлөмж болгож байна.

3. “Бүрэн хангалттай” буюу 100 хувьтай үнэлэгдсэн 27 арга хэмжээний үр дүнг цаашид бууруулахгүйгээр чанаржуулж, хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах шаардлагатай.

--o0o--